

Ажилгүйдэл, инфляци

Нийгэм судлал 10-р анги

Багш Д.Уранцэцэг

II улирал. Хичээл

[Email: D.Urantsetseg@must.edu.mnt](mailto:D.Urantsetseg@must.edu.mnt)

Утас: 99291533

Хичээлийн зорилго

- Ажилгүйдэл, инфляцид холбогдох мэдээллийг шинжлэн, эрсдлээс өөрийгөө хамгаалах шийдэл дэвшүүлэх
- Ажилгүйдэл, инфляцийн талаарх судалгааны сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлтийг нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжил, байршил зэрэг үзүүлэлтийг дүрсэлж тайлбарлах.

Тулгуур ойлголт

Макро эдийн засаг-эдийн засгийн бүтэц, үйл хөдлөл, шийдвэр гаргалт, үр дүнг бүхэлд нь нэгтгэдэг эдийн засгийн салбар юм.

Ажилгүйдэл- Тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдийг ойлгоно.

Ажилгүйдлийн түвшин: Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувийн жингээр тодорхойлно.

Ажиллах хүчний оролцооны түвшин: Хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно.

Инфляци- Мөнгөний ханш буурах үйл явц юм.

Тулгуур ойлголт

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг түүний хэрэглээнд эзлэх жингээр үржүүлээд нэмснээр гардаг.

Хөдөлмөрийн нас: “Хөдөлмөрийн тухай” Монгол Улсын хуульд заасны дагуу 15-59 насны хүн амыг хамруулна.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам: Эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам, хөдөлмөрийн насанд хүрээгүй болон хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч): Тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

Ажилгүйдлийн шалтгаан

Үүсэх үндсэн нөхцөл

1. Нийт эрэлтийн бууралтаас хамаараад ажилгүйдэл бий болно.
2. Үйлдвэрлэлийн уналтын үед хүн ам, үйлдвэр, аж ахуйн газрууд бүтээгдэхүүн ба үйлчилгээг худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээ багасна.

Ажилгүйдлийн шалтгаан

- Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил сул дорой
- Боловсролын тогтолцоо муу
- Шилжилт хөдөлгөөн
- Гадаадын ажилллах хүчний импорт

Ажилгүйдлын төрлүүд

Шилжилтийн

Хүн амын аливаа шилжилт хөдөлгөөнөөс үүсэн бий болох ажилгүйдэл

Улирлын

Ажил мэргэжлээс шалтгаалан бий болж байгаа ажилгүйдэл

Бүтцийн

Ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан, техник технологи, хөгжил дэвшилтэй нийцэж чадаагүйгээс үүснэ

Мөчлөгийн

Эдийн засгийн уналт сэргэлт зэрэг эдийн засгийн тогтворгүй байдалтай уялдан бий болдог

Артур Оукерийн хууль

Ажилгүйдлийн улмаас үйлдвэрлэлийн хүчин чадлыг дутуу ашиглаж, ДНБ-ийг нэмэгдүүлэх боломж алдаж байгааг Артур Оукерийн хуулиар илэрхийлнэ. Ө.х ажилгүйдлийн түвшин хэвийн ажилгүйдлийн түвшнээс 1%-иар их байх юм бол ДНБ-ийн хэмжээг 2.5%-иар нэмж үйлдвэрлэх боломж алддаг гэж үздэг байна.

- Жишээ нь, ажилгүйдлийн түвшин хэвийн ажилгүйдлийн түвшнээс 3.5%-иар их байвал ДНБ-ийн үйлдвэрлэл 8.75%-иар хоцорсон гэсэн үг. (2.5% x 3.5%)

Ажилгүйдлийг бууруулах арга зам

Үүнд:

1.Эдийн засгийн аргаар бууруулахад ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, цалин хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн багтаамж ихтэй жижиг, дунд үйлдвэрүүдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх

2.Захиргааны аргаар бууруулахад Хөдөлмөрийн биржийн албыг бэхжүүлэх, мэдээллийн сүлжээ бий болгох, мэргэжил олгох давтан сургах, зориудын сургалтыг зохион байгуулах

3.Гадаад хүчин зүйлсийг ашиглах арга нь ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэлээр хамтарсан хөрөнгө оруулалт хийх, ажиллах хүчийг экспортлох

Инфляцийн шалтгаан

Инфляци бол мөнгөний зах зээл дээр үүсч төрдөг.

- 1.Төв банкны гүйлгээний хүрээн дэх мөнгөний бодлогын буруугаас болж мөнгөний массыг таваараар хангаж чадахгүй бол инфляци үүсдэг.
- 2.Төв банкнаас засгийн газар тогтмол зээл авах нь .
- 3.Эдийн засгийг цэрэгжүүлэх нь.
- 4.Зах зээлийг монополизлох нь.
- 5.Гадаад эдийн засгийн хүчин зүйл нь.

Инфляцийн төрлүүд

- Албадмал инфляци нь таваарын хомсдолд оруулж барааг бараагаар солих (бартер) хэмжээнд хүргэж эдийн засгийг ухраахад хүргэдэг.
- Гипер инфляци нь (жолоодлогогүй) мөнгө өөрийнхөө үүргийг үлэмж ихээр алдахад үүсдэг.
- Зохиомол инфляци нь зах зээлийн механизмыг гажуудуулж эдийн засгийн үр ашгийг бууруулдаг.

Дасгал 1

Дараах зураг дээр 2018, 2019 оны инфляцийн түвшинг <https://dnn.mn/инфляци-буурчээ/> линкээр орж сайтар уншаад, гол ойлголтуудыг дэвтэртээ бичих .



Дасгал 2 Тохиолдол шинжлэх

Гарьд 45 настай. Түүний гурав дахь хүү Тэнгис 17 настай. Дараа жил дээд сургуульд элсэн орох зорилготой бөгөөд түүний орохыг хүссэн дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 1000000 (нэг сая) төгрөг байна. Иргэн Гарьд хүүгийнхээ сургалтын төлбөрт зориулж 1000000 төгрөгийг нэг жилийн хугацаатай, жилийн 15 хувийн хүүтэй хадгаламжид хийв. ГЭТЭЛ!!! Жилийн дараа инфляцийн түвшин 20 хувиар өссөн тул Тэнгисийн элсэн орохоор төлөвлөж байсан дээд сургууль нэг жилийн сургалтын төлбөрөө 20 хувиар нэмэгдүүлжээ.

Үүний үр дагавар нь юу болох вэ?

Дасгал 3

Дараах бодлогыг бодоорой.

Жишээ нь: Өнөөдөр 6000 төгрөгний үнэтэй байсан 1 кг хонины мах нэг сарын дараа 7000 төгрөгний үнэтэй болсон гэж бодъё. Тэгвэл 1 кг хонины мах худалдаж авахын тулд дахиад 1000 төгрөг хэрэгтэй. Гэтэл цалин, тэтгэврийн хэмжээ энэ хугацаанд нэмэгдээгүй. Иймээс мах авахын тулд яах вэ?

Гэрийн даалгавар

1. Ажилгүйдэл, инфляци сэдэв нь сурах бичиг дээр бичигдээгүй Монголбанкны мэдээлэл орсон тул багшийн бэлтгэсэн хичээлийг сайтар уншиж дэвтэртээ тэмдэглэж уншиж судлаарай.
2. Сурах бичгийн 81-88-р хуудаснаас уншаад гол ойлголтуудыг дэвтэртээ тэмдэглээрэй.
3. Дасгал 1,2,3-г дэвтэртээ хийгээрэй.